



С. БУЯНЗАЯА

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сүргүүлийн
Иргэний болон захиргааны хэргийн
шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн
эрх зүйн техникийн багш, докторант

АЛБАДАН АЖИЛ ХИЙЛГЭХ ЯЛ, НИЙТЭД ТУСТАЙ АЖИЛ ХИЙЛГЭХ ЯЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛАХ НЬ

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хийгдэж байгаа багц хуулийн төслийн нэг бол өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль болох Эрүүгийн хууль юм. Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулж боловсруулсан “Гэмт хэргийн тухай” хуулийн төслийг Улсын их хуралд өргөн бариад байна.

Эдгээр хоёр хуульд агуулгын хувьд ижил боловч нэршлийн хувьд ялгамжтайгаар хуульчилсан Эрүүгийн хуулийн албадан ажил хийлгэх ял, Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд тусгагдсан нийтэд тустай ажил хийлгэх ялын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан, тухайн ялын онцлог шинжийг тодруулахыг зорилоо.

Үзүүлэлт	Эрүүгийн хууль	Гэмт хэргийн тухай хуулийн төсөл
Хуулийн бүлэг, зүйл	31 бүлэг, 305 зүйл	30 бүлэг, 274 зүйл
Ерөнхий ангийн бүлэг, зүйл	13 бүлэг, 79 зүйл	9 бүлэг, 68 зүйл
Тусгай ангийн бүлэг, зүйл	17 бүлэг, 226 зүйл	20 бүлэг, 206 зүйл
Ялын зорилго	Иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргийн улмаас зорчигдсон эрхийг сэргээх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд оршино.	Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хохирлыг ноход толүүлэх, гэмт хэргийн улмаас зорчигдсон эрхийг сэргээх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино.
Ялын нэршил	Албадан ажил хийлгэх	Нийтэд тустай ажил хийлгэх

Ялын тодорхойлолт	Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлсон газарт нийгэмд ашигтай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг хэлнэ.	Гэмт хэргийн тухай хуулийн тусгай ангид заасан тохиолдолд шүүхээс тодорхойлсон газарт нийтийн ашиг сонирхолд тусгай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг хэлнэ.
Ялын төрөл	1. Торгох 2. Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах 3. Эд хөрөнгө хураах 4. Албадан ажил хийлгэх 5. Баривчлах 6. Хорих 7. Цаазаар авах.	Хүнд оногдуулах ял: 1. Торгох 2. Нийтэд тусгай ажил хийлгэх 3. Зорчих эрхийг хязгаарлах 4. Хорих 5. Эрх хасах. Өсвөр насны хүнд оногдуулах ял: 1. Нийтэд тусгай ажил хийлгэх 2. Зорчих эрхийг хязгаарлах 3. Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих 4. Эрх хасах. Хуулийн этгээдэд оногдуулах ял: 1. Торгох 2. Эрх хасах 3. Таган буулгах.
Ялын хугацаа	100 – 500 цаг	120 – 480 цаг
Одорт хийх ажлыг хугацаа	3 – аас доошгүй цагаар	4 – өөс дэшингүй цагаар
Ялын чанар	Үндсэн	Үндсэн ба нэмэгдэл
Цагдан хоригдсон хугацааг тооцох	Цагдан хоригдсон 1 хоногийг албадан ажил хийлгэх ялын 8 цагтай тэнцүүлж хасч тооцно	Тооцохгүй
Ялыг өөр төрлийн ялаар солих	Албадан ажил хийх 8 цагийг 1 хоногийн баривчлах ялаар солино	Нийтэд тусгай ажил хийх 8 цагийг 1 хоногийн хорих ялаар солино
Ял оногдуулах санкц бүхий зүйл, заалт	39 зүйл ангийн 46 заалт	Байхгүй
Ял оногдуулж болохгүй субъект	- Хөдөлмөрийн чадваргүй этгээд - Жирэмсэн эмэгтэй - Гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, ганид бие эцэг - 55-аас дээш насны эмэгтэй - 60-аас дээш насны эрэгтэй - Цэргийн жинхэнэ хугацааг алба хааж байгаа этгээд	- Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн - Жирэмсэн эмэгтэй - 55-аас дээш насны эмэгтэй - 60-аас дээш насны эрэгтэй
Ялаас чөлөөлөх	Шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 3 жил өнгөрсөн бол ялаас чөлөөлнө.	- Гэмт хэрэг үйлдэж ял шийтгэгдсэний дараа сэтгэцийн эмгэгтэй болж өөрийн үйлдлийн бодит шинж чанар, хор уригнийг ухамсарлах, үйлдлээ удирдан жолоолох чадваргүй болсон хүнийг ял эдлэхээс чөлөөлж эмнэлэгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэнэ. - Шүүх гэмт хэрэг үйлдэж ял шийтгэгдсэний дараа ял эдлүүлэхэд саад болохуйц өөр өвчнөөр өвчилсөн хүнийг ял эдлэхээс чөлөөлж болно.

Дээрх 15 төрлийн үзүүлэлтээр Эрүүгийн хууль болон Гэмт хэргийн

тухай хуулийн төсөлд тусгагдсан “Албадан ажил хийлгэх”, “Нийтэд тустай ажил хийлгэх” ялын эрх зүйн зохицуулалтын ялгаатай болон төсөөтэй талыг судлан үзлээ.

Шинээр боловсруулагдсан Гэмт хэргийн тухай хуулийн төслийн энэ талаарх эрх зүйн зохицуулалтын хувьд дүгнэн үзээд дараах дүгнэлтийг хийж, тодорхой хэдэн саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Нийтэд тустай ажил хийлгэх ялыг өдөрт дөврөөс дээшгүй цагаар эдлүүлнэ гэсэн нь ял эдлүүлэх ажиллагааг удаашруулж байгаа хэлбэр гэж үзэж байна. Хамгийн доод талдаа 120 цагийн нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулсан гэж үзэхэд 30 хоног, 480 цагийн ял оногдуулахад ял эдлүүлэх ажиллагаа 4 сар тасралтгүйгээр үргэлжилэх тооцоо гарч байна. Иймд эрх зүйн зохицуулалтын хувьд нийтэд тустай ажил хийлгэх ялыг өдөрт дөрвөөс доошгүй, наймаас дээшгүй цагийн хугацаагаар эдлүүлнэ гэж өөрчлөлт оруулах нь зүйтэй.

2. Нийтэд тустай ажил хийлгэх ялыг үндсэн ба нэмэгдэл ялын чанартайгаар оногдуулна гэж заасан хэдий боловч цагдан хоригдсон хугацааг ял эдлэхээс хасч тооцох эрх зүйн зохицуулалт байхгүй байна. Ямар ч төрлийн ялаар шийтгүүлсэн этгээдэд цагдан хоригдсон хугацааг хасч тооцох нь шударга ёсны зарчим болно.

Иймд нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн этгээд цагдан хоригдож байсан бол цагдан хоригдсон нэг хоногийг нийтэд тустай ажил хийлгэх 8 цагтай тэнцүүлэн эдлэх ялаас хасч тооцно гэж эрх зүйн зохицуулалт оруулах шаардлагатай.

3. Нийтэд тустай ажил хийлгэх ялыг үндсэн ба нэмэгдэл ялын чанартайгаар оногдуулахаар эрх зүйн зохицуулалт хийсэн боловч энэхүү ялыг үндсэн ял дээр нэмэгдэл ялын чанартайгаар оногдуулсан тохиолдолд ялыг хэдий үеэс эхлэн тооцох тухай зохицуулалт байхгүй байна.

Иймд дараах эрх зүйн зохицуулалтыг нэмж хуульчилах шаардлагатай. Үүнд:

- Нийтэд тустай ажил хийлгэх ялыг дангаар нь үндсэн ялын чанартай эсхүл торгох, зорчих эрхийг хязгаарлах ялд нэмэгдэл ялын чанартайгаар оногдуулсан бол хугацааг нь шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон үеэс эхлэн тооцно.

- Нийтэд тустай ажил хийлгэх ялыг хорих ялд нэмэгдэл ялын чанартайгаар оногдуулсан бол хугацааг нь үндсэн ялыг эдэлж дууссан үеэс эхлэн тооцно.

4. Хүнд, өсвөр насны хүнд болон хуулийн этгээдэд оногдуулах ялын төрөл гэж ангилан авч үзэж нийтэд тустай ажил хийлгэх ялыг хуульчилсан боловч хуулийн төсөлд тусгагдсан нийт ял оногдуулах гэмт хэргийн зүйл, заалтад нийтэд тустай ажил хийлгэх ялыг оногдуулах санхүүгийн гэмт хэрэг байхгүй байх бөгөөд энэ нь ялын үр нөлөөгүй байдлыг илтгэн харуулж

байна.

Иймд тодорхой төрлийн гэмт хэргийн зүйлчлэл дээр нийтэд тустай ажил хийлгэх ялыг үндсэн ялын чанартайгаар, зарим тохиолдолд нэмэгдэл ялын чанартайгаар оногдуулж болохоор хуульчилах нь зүйтэй юм.